

**“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2018.04.30-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэл**

2018.04.30 өдөр

Улаанбаатар хот.

“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 сарын 30-ны өдрийн 14 цаг 10 минутанд “Баянгол” зочид буудлын хурлын өрөөнд эхлэв.

Хуралд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ө.Хүдрээ, Санхүү эрхэлсэн захирал Б.Мянганбаяр, хурал зохион байгуулах комиссын гишүүн Д.Тогосбаатар, Тооллогын комиссын даргаар Б.Мянганбаяр, гишүүнээр О.Ганчимэг нар мөн нийт 6 хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар, 5 хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр оролцов.

Тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр: “Хай Би Ойл” ХК-ийн 2018 оны 04 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг та бүхэнд танилцуулья. Нийт 52,118,954 хувьцаанаас нийтдээ 78,70% буюу 41,020,197 ширхэг хувьцаа эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хурлын ирц бүрдэж байгааг мэдэгдье.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Юуны өмнө манай компанийн хувьцаа эзэмшигч иргэд, ААН-дэд хуралд ирсэнд талархан, энэ өдрийн мэндийг хүргэж хурлаа нээж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит хурлын дэг болоод хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулья.

- ✓ Хурлын ирцийг бүртгэх
- ✓ Хурлын ирцийг мэдээлэх
- ✓ Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах
- ✓ Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах
- ✓ Хурлын завсарлага
- ✓ Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- ✓ Хурлыг хаах

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2018 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2018 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын дарга Ө.Хүдрээ: Өнгөрсөн жилийн үйлдвэрийн үйл ажиллагааны талаар таинилцуулья. 2017 оны ажил эхлэхээс өмнө урьдчилсан засвар үйлчилгээ хийсний

дүнд тос дахин боловсруулах үйлдвэрлэлд гэнэтийн буюу онц ноцтой гэмтэл зөрчил гараагүй жигд, хэвийн ажилласан. Тайлант хугацаанд 1'015'680 литр хаягдал тос буюу үйлдвэрийн түүхий эдийг цуглуулахад 269'160'410 төгрөгийн зарлага гарсан ба үүний 22,4 хувийг аж ахуйн нэгж, 77,6 хувийг хувь хүнээс худалдан авсан. Үүнээс харахад нэг литр ажилласан маслыг дунджаар 265 төгрөгөөр худалдаж авсан байна. 2017/03/15-аас 2017/12/31-ний өдрийг хүртэл тос боловсруулах үйлдвэр нь ажилласан ба энэ хугацаанд нийт 670'938 литр мазут М-100 үйлдвэрлэж үүнээс нийлбэр дүнгээр 711'528 литрийг 617'572'200 төгрөгөөр борлуулалт хийсэн байна. 2016 оны мазутын борлуулалтын орлого 493'768'200 төгрөг байсан бол 2017 онд мазутын борлуулалтын орлого 617'572'200 төгрөг болж өмнөх оноос 123'803'800 төгрөгөөр буюу 25,07 хувиар өссөн байгаа. 2016.12.30-ны өдрийн байдлаар түүхий эд материал (ТЭМ) нийт 72'039 литр, боловсруулсан бүтээгдэхүүн буюу мазут 36'035 литр нөөцтэй байсан бол 2017.12.30-ны өдрийн байдлаар ТЭМ 363'806 литр, боловсруулсан бүтээгдэхүүн буюу Мазут 36'035 литрийн үлдэгдэлтэй байгаа. 2017 оны 03 дугаар сард ажил эхлэхээс өмнө үйлдвэрийн ЦТП-нд цахилгааны трансформаторын тос сольж, жийрэг, шаазан, цэнэг шавхагч, 380В цахилгаан тоолуур гээд тодорхой хэмжээний зардал гаргасан. 4 дүгээр сард дотор 25-н саванд тунгаах шүүр, хөлдөж хагардаг хуванцар хоолойг ган хоолойгоор сольсон. Зарим Монголд олдоогүй эд материалыг Хятад улсад захиалж засвар үйлчилгээг хийсэн байгаа. Бусдаар бол үйлдвэрлэлд саатах хэмжээний гэмтэл гараагүй. Мөн ажилчдыг тээвэрлэх унаа машин болон тосны цистернд ээлжит урсгал засвар, улсын үзлэг, оношилгоонд хамруулж, АТБӨЯТХ-ийн татвар, хот дотор тос тээвэрлэх түр зөвшөөрлийг 2017 он дуустал авсан байна. Мөн үйлдвэрт тосны тусгай зориулалтын 24'000 литрийн автоцистерн худалдан авсан ба энэ нь уул уурхай, хөдөө орон нутагт түүхий эд болоод бэлэн бүтээгдэхүүнийг тохирсон хэмжээгээр зөөж тээвэрлэх зориулалтаар ажиллах юм. 2017 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 5 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 2 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 15 ширхэг гэрээнүүдийг байгуулсан. Бүтээгдэхүүн худалдах худалдан авах гэрээний 10-аад гэрээ нь ТЭМ-ын гэрээ байгаа бол 5 гэрээ нь мазут нийлүүлэх гэрээ байна. Энэ жил нилээд олон засварын төвүүд манайхтай гэрээ хийсэн. Ирэх жил мөн ТЭМ нийлүүлэх байгууллага ихсэх хандлагатай байна.

Борлуулалтын тухайд: 2018 онд Нийслэлийн автозамын хөгжлийн газраас Улаанбаатар хотод нийт 63 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, нийт 43,5 км авто зам, 3050 урт метр гүүр барина хэмээн мэдээлсэн. Тиймээс манай байгууллагатай хамтарч ажилладаг томоохон авто зам барилгын компаниуд нь урьдчилсан байдлаар 1'400 тонноос багагүй мазут авахаар санал өгсөн байгаа. Одоо байгаа түүхий эдийн нөөц хүрэлцэхгүй байгаа тул 2018 оны 4 сараас эхлэн 6 сар хүртэл нийт 300 тонноос багагүй түүхий эдийг нөөцөлж авах шаардлагатай байна. Үүний тулд хаварын цагт авто засвар, уул уурхайн засварын газруудаар үүсэх бохир тосыг өрсөлдөгчдөд алдахгүйгээр цуглуулж авах нь чухал болоод байна. Зуны цагт ТЭМ-ын эрс багасдаг тул хувь хүмүүс болоод тосны ченжүүдтэй харилцан ашигтай байхаар хэлэлцэж, техникийн хаягдал тосыг тухай бүрт бэлэн байхаар ажлыг төлөвлөж байгаа болно.

Үйлдвэрийн боловсруулах үйл ажиллагааг хэвийн жигд ажиллуулахын тулд боловсруулах тоног төхөөрөмжийн үзлэг оношилгоог сайтар хийж, гэмтэх магадлалтай жижиг сэлбэг хэрэгслийг нөөцөлж авах шаардлагатай байгаа. Тиймээс

2018 оны эхний хагас жилд дараах ажил үйлчилгээнүүдийг хийхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Үйлдвэрийн хашаанд байгаа өдөр хүчдэлийн трансформаторын тосны бакны жийрэг солиулж, трансформаторын тос нэмэх.
2. Худгаас үйлдвэр хүртэлх хөргөлтийн усны хоолойг шалган угсрах.
3. Боловсруулсан бүтээгдэхүүн болон түүхий эдийг худалдах, худалдан авах гэрээнүүдийг шинэчлэн хийх.
4. Байгаль орчны, гамшгийн үнэлгээ, галын дүгнэлт гаргуулах.
5. Галын аюулгүй байдлын багаж хэрэгслийг гүйцээж авах.
6. Машин техникуудийг үзлэг оношилгоонд оруулахад бэлдэх.
7. Тосны машин, ажилчдын машины хот доторх болон ЕС зөвшөөрлийг авах.
8. Авто тээврийн хэрэгслүүдийн татвар хураамжийг төлөх.
9. Тосны үйлдвэрийн орчны тохижилт, бошиктой болон задгай савтай ажилласан маслыг цуглуулах талбайн бетон цутгалтыг хийж, хашлага, тэмдэг тэмдэглэгээг хийнэ.

Мөн өнгөрөх жилийн үйл ажиллагааны санхүүгийн тайлан, ТУЗ-ын ажлын тайлан болоод ТУЗ-н дэргэдэх аудитын хороо аудит явуулж тайлан гаргаж өгсөнг хурлын материалд оруулсан байгаа. Үүнээс санхүүгийн үзүүлэлтүүдээс дурдвал:

Компани нь санхүүгийн тайлан балансыг гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, газрын төлбөр, авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь харьяа дүүрэг, татварын хэлтэсд хүргүүлж байгаа. 2017 оны байдлаар 711.52 мянган литр мазут борлуулж 561.5 сая төгрөгийн орлого олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 420.1 сая төгрөг зарцуулсан бөгөөд үйл ажиллагааны зардалд 298.4 сая төгрөг, хүүгийн орлого 98.5 сая төгрөг, валютын ханшийн зөрүүний алдагдал 23.3 сая төгрөг, үйл ажиллагааны бус бусад зардалд 17,7 сая төгрөг тайлагнан ажилласан байна. Мөн “Хай Би Ойл” ХКомпани үйл ажиллагаагаа өргөжүүлэн 2013 онд газрын тосны хайгуул олборлолтын чиглэлээр Хойд Солонгосын Korea Oil Exploration Corporation (КОЕС) компанийн 20 хувийг эзэмшдэг Ninox Hydrocarbons (L) Berhad (NHLB) компанийг худалдан авах авсан. 2017 оны 1 сарын 12-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын Сангийн яамны Гадаад Хөрөнгийн Хяналтын Алба нь БНАСАУ-ын төрийн өмчит Korea Oil Exploration Corporation (КОЕС) АНУ-ын “DPRK3” хориг арга хэмжээний хүрээнд жагсаалтанд бүртгэснийг мэдэгдснээр “Хай Би Ойл” ХК нь улс төрийн давагдашгүй хүчин зүйлийн дагуу БНАСАУ дахь төслөө цаашид үргэлжлүүлэх боломжгүй болж хамтарсан компаниас татгалзах, хамтран ажиллах гэрээг цуцлахад хүрсэн. Манай охин компанид оруулсан хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал болох 4,675.3 сая төгрөгийг алдагдлаар бүртгэх шийдвэрийг ТУЗ-аар хэлэлцэн батлуулсан. “Хай Би Ойл” ХКомпани нь 2017 онд НДШ-д 45,5 сая төгрөг, ААНОАТ-т 9,8 сая төгрөг, ХХОАТ-т 36,5 сая төгрөг, НӨАТ-т 56,1 сая төгрөг, газрын төлбөр 1,6 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварт 9,9 сая төгрөг, АТӨЯХАТ-0,4 сая төгрөг нийт 150,1 сая төгрөг төлөхөөр тайлагнасан байна. Тайлант онд компанийн нийт хөрөнгө 4,835,401.6 мянган төгрөг байгаа бөгөөд урд оноос 5,291,808.9 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт хөрөнгийг дотор нь задалбал: дансан дахь мөнгө 13,641.0 мянган төгрөг, нийт авлага 1,772,654.6 мянган төгрөг, бараа түүхий эд материал урьдчилж гарсан зардал 154,797.1 мянган төгрөг эргэлтийн бус хөрөнгө 2,894,308.9 мянган төгрөг байна. Өр төлбөр эзэмшигчийн

өмчийн дүн 4,835,401.6 мянган төгрөг байгаас 489,855.7 мянган төгрөг нь богино хугацаат өр төлбөр, татварын өглөг 106,046.0 мянган төгрөг байна. Эздийн өмчийн дүн 4,239,499.9 мянган төгрөг байгаа нь өмнөх жилээс 3,699,933.5 мянган төгрөгөөр буурсан. Манай компани нь тайлант хугацаанд улс, орон нутгийн төсөвт 134,1 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн байна. Нийт татвар шимтгэлийн 42,953.5 мянган төгрөг нь НӨАТ-ийн татвар, Үл хөдлөх хөрөнгийн татварт 7,437.7 мянган төгрөг, газрын төлбөрт 780,1 мянган төгрөг, ХАОАТ-т 32,885.5 мянган төгрөг, Агаарын бохирдол, АТӨЯХАТ 417.2 мянган төгрөг, ААНОАТ-т 7,385.2 мянган төгрөг, ЭМ, НД-ын шимтгэлд нийт 42,257.1 мянган төгрөг зэргийг төлсөн байна. Энэ бүгдийг аудитын хороо болон хараат бус аудиторын үнэлэлт дүгнэлтээр тайлагнасан байгаа. Энэ жилийн хараат бус аудитороор Монголд урдаа барих “Далайван аудит” ХХК ажилласан байгаа. Хараат бус аудиторын дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя (“Далайван аудит” ХХК-ийн тайланг уншиж танилцуулав). Үйлдвэртэй холбоотой үйл ажиллагааны талаар товчхондоо та бүхэнд танилцуулахад ийм байна. Манай компанийн ТУЗ нь 2017 оны ажлын тайлангаа хурлын материалд оруулсан. Үүнээс дурдвал: 2017 оны ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосоноос хойш 2017 оны 05 сарын 23-ны өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг томилсон. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын дэд хороог Х.Батхишиг даргалж, гишүүдээр Б.Пүрэвбаатар, Б.Болормаа нар, ТУЗ-н дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Ж.Эрдэмбилэг даргалж, гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн нар, Нэр дэвшүүлэх дэд хороог Б.Мянганбаяр даргалж, гишүүдээр Х.Батхишиг, М.Батсүрэн нар тус тус томилогдон ажилласан. Тайлант хугацаанд нийт 5 удаа хуралдаж 9 тогтоол батлагдаж гарсан ба “Ногдол ашиг хувиарлах эсэх тухай”, “Аудитын тайлан дүгнэлт батлах тухай”, “Алдагдалаар бүртгэх тухай”, компанийн санхүү эдийн засагтай холбоотой 3 асуудлыг шийдвэрлэсэн. Мөн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай”, “ТУЗ-ын дарга, нарийн бичиг, Санхүү эрхэлсэн захирал томилох тухай”, “ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох тухай” зэрэг компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 6 асуудал хэлэлцэн шийдвэр гаргаж байсныг компанийн нээлттэй, ил тод байх зарчмыг хангахын тулд өөрийн болон МХБ-н сайтад зохих материалуудыг цаг тухайд нь байрлуулж байсан. Мөн үүнээс гадна компанийн засаглалын үндэсний портал сайтад мэдээлийг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад зориулан байрлуулсан. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна. Компани нь хувьцаа эзэмшигчдэд 2017 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан байгаа.

Одоо хурлын дэгийн дагуу асуулт хариулт явуулъя.

“Хай Би Ойл” ХКомпанийн үйл ажиллагаа, санхүү, аудиторын дүгнэлт, ТУЗ-н ажлын тайлан гээд бусад холбоотой асуудлаар тодруулж асуух зүйл байвал асууж болно.

Асуулт тавьсан хувьцаа эзэмшигч байсангүй.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Асуулт байхгүй бол хурлын дэгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ажилласан Б.Мянганбаяр гишүүн танилцуулна.

ТУЗ-н дэргэдэх нэр дэвшүүлэх дэд хорооны дарга Б.Мянганбаяр: 2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн нэр дэвшигчдэд өмнө нь ажиллаж байсан хараат 5-н гишүүн дээр 3 хүн, хараат бус 4 гишүүн дээр 1 хүн нэрээ дэвшүүлсэн. Өмнөх гишүүдийг та бүхэн таних байх тиймээс шинээр нэр дэвшигдсэн хүмүүсийн товч тодорхойлолтыг уншиж танилцуулъя.

Хараат гишүүнд нэр дэвшсэн Ө.Батсайхан - 1999 онд Улаанбаатар хотын МУИС-ийн ОУХДСургуулийг Олон улсын харилцааны бакалавр, 2003 онд ОХУ-ын Москва хотын Дипломат Академийг Олон улсын харилцааны магистр, 2011 онд Улаанбаатар хотын СЭЗДСургуулийг Бизнесийн удирдлагын магистраар төгссөн. Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн 3 жил, ЗТАЖЯамны мэргэжилтэнгээр 3 жил, ХБНГУ-ын “Гауфф инженеринг” компанийн суурин төлөөлөгч 2 жил, МУ-ын Элчин сайдын яам, Австри улсын Консулын ажилтнаар 3 жил тус тус ажиллаж байсан. Б.Батнайрамдал - 2010 онд Улаанбаатар хотын Их засаг их сургуулийг Хуульч мэргэжлээр бакалавраар төгссөн. “Үнэмлэхүй эрх” ХХК-д 2 жил туслах ажилтнаар, “ХОТ” ХХК-д хуулийн зөвлөх ажилтнаар 4 жил ажиллаж байна. Сүүлд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-н нарийн бичгээр ажилласан. Б.Мягмаржав – 2008 онд ШУТИС ГУУСургуулийг уул уурхайн ашиглалтын инженер бакалавр, 2013 онд ГУУСургуулийн магистр, 2015 онд Канад улсын “Alberta” их сургуульд Англи хэлний сургалт, 2017 онд Канад улсын “Alberta” их сургуулийг Уулын инженерийн магистраар төгссөн. “Эрдэнэт” УБҮ-т туслах инженер 1 жил, Уул уурхайн ашиглалтын “Ej Balley” вэб сайтын захирал 1 жил, МУ-н Газрын тосны газрын мэргэжилтнээр 2 жил, МУ-н Уул уурхайн яаманд мэргэжилтнээр 2 жил ажилласан туршлагатай. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн Б.Батчулуун - Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургуулийг 2000 онд Нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. “Сити Баз Консалтинг” ХХК-д Санхүү, бүртгэл, төлөвлөлтийн хэлтсийн даргаар 1 жил, Төрийн банкны тооцооны төвийн захиралаар 4 жил, Хадгаламж банкны тооцооны төвийн захирлаар 3 жил ажилласан туршлагатай ба одоогоор Хаан банкны эдийн засагч, ахлах эдийн засагчаар 4 жилдээ ажиллаж байна. Эдгээр хүмүүс нь “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-д шинээр нэр дэвшиж байна.

Хурлын дарга Ө.Хүдрээ: ТУЗ-д нэр нь дэвшигдсэн гишүүдтэй танилцлаа. Одоо санал хураалтаа аваад хурлын дэгийн дагуу 10 минут завсарлана. Завсарлах хугацаанд тооллогын комисс дүгнэлтээ гаргаад танилцуулна.

Хурлын төгсгөлд тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр санал хураалтын дүнг танилцуулав:

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 78,70 % буюу 41,020,197 ширхэг хувьцаа эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирснээс 11 саналын хуудас буюу 100 % -ийн хүчинтэй саналын хуудас байлаа.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

3. 2018 оны ажлын төлөвлөгөөг батлаж хэрэгжүүлэх тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

4. Хуралд оролцож буй нийт хувьцаа эзэмшигчдээс компанийн шинэ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигч **Ж.Эрдэмбилэг 21.51%, Б.Мянганбаяр 21.51%, Б.Батнайрамдал 21.11%, Б.Мягмаржав 21.11%, Б.Лхагвадорж 6.99%, Ө.Хүдрээ 6.99%** нар хувийн саналыг авч хараат гишүүдэд сонгогдлоо. Мөн хараат бус гишүүдэд **М.Батсүрэн 32.41%, М.Батчулуун 33.33%, Б.Болормаа 33.33%** нар нь хувийн саналтайгаар сонгогдлоо.

5. ТУЗ-н 2018 оны зардлын төсвийг батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах тухай хувьцаа эзэмшигчид 100 % нь зөвшөөрсөн, 0 % нь татгалзсан, 0 % нь түдгэлзсэн байна.

Хурлын дарга Ө.Хүдрээ: Энэ удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит тайлангийн хурлаар гаргасан тогтоолыг Тооллогын комиссын дарга Б.Мянганбаяр танилцууллаа. Шинээр “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ-д сонгогдсон гишүүдэд нийт хувьцаа эзэмшигчдийн өмнөөс баяр хүргэж, ажлын амжилт хүсье. Мөн манай компанийн энэ удаагийн хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд баярлалаа.

Хурал хаасныг мэдэгдье.

Хурал 15 цаг 23 минутанд өндөрлөв.

Хурлын протокол хянасан хурлын дарга: **Ө.ХҮДРЭЭ**

Хурлын протокол хөтөлсөн: **Д.ТОГОСБААТАР**

